

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛЫН 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024.06.12

№	Эрх зүйн актын он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц /үр дүн/	Хэрэгжилтийн хувь
ГЗБГЗЗЕГазрын даргын тушаалын биелэлт				
2024 он				
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.02.07 А/40 дугаар тушаал	“Бүтээлч ажлын төлөвлөгөө” батлах тухай	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн мэргэжлийн байгууллагын үүсэж хөгжсөний 70 жилийн ойг угтаж, хийх 66 заалт бүхий төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Газрын харилцааны 1 Киоск машиныг шинээр авахаар захиалга өгсөн 6 сард багтаан авахаар болсон.	60%
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.02.20 01 дүгээр Албан даалгавар	“Бүсчилсэн хөгжлийг дэмжих Хариуцлагатай газрын харилцаа” нэрэмжит жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	“Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд байгууллагын хэмжээнд тусгай төлөвлөгөө гарган ажиллаж аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай болон ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын судалгааг гаргаж газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр ногдуулсан. “Бүсчилсэн хөгжлийг дэмжих Хариуцлагатай газрын харилцаа” нэрэмжит жилийн хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай албан даалгаварт заасан 10 чиглэл тус бүрийн биелэлтийг орон нутагт ханган ажиллаж байна.	100%
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.02.23 А/51 дүгээр тушаал	Журам батлах тухай	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/51 дугаар тушаалыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%

4	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.03.18 А/83 дугаар тушаал	Харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлогын зарцуулалтын талаар авах арга хэмжээ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалыг байгууллагуудын өөрийн орлогын зарцуулалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна.	100%
5	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.03.19 А/88 дугаар тушаал	Хариуцлагатай газрын харилцааны аян зохион байгуулах тухай	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 04-р сарын 02-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “Хариуцлагатай газрын харилцаа” аяныг орон нутагт 2024 оны 04-р сарын 01-ний өдрөөс 5-р сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулсан. Тус аяны зорилго болох салбарын хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас газар түүний хөрсөнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан тодорхой давтамжтай олон нийтэд хүргэж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авсан. Аяны төлөвлөгөөний биелэлтийг 7 хоногийн 4 дэх өдөр бүр ГЗБГЗЗГ-т хүргүүлэн ажилласан.	100%
6	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024.05.21 А/173 дугаар тушаал	Мөнгөн урамшуулал олгох тухай	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/173 дугаар тушаалын дагуу газрын даргад 5 жилийн мөнгөн урамшууллыг олгосон.	100%

ГХБХБГазар